

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

1. Үндсэн үйл ажиллагаа

Газрын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. “Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар”, “17 дугаар сургууль”, “27дугаар цэцэрлэг” зэрэг байгууллагуудын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.

“Жаргалант сумын Хоршоо хөгжлүүлэх сан”, “Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төв”, “Баян-Өндөр сумын Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”, “Мэнд цэцэн өрхийн эрүүл мэндийн төв”, “Орон нутгийн өмчийн газар”-ийн 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дуусгаж тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Архивын улсын үзлэг шалгалт болохтой холбоотой ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.



Байгууллагын 2025 оны III улирлын “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан”-г аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-д хүргүүлсэн.

Засгийн газрын 2025 оны 24 дүгээр хуралдааны тэмдэглэлийн хэрэгжүүлэх арга хэмжээний байгууллагад холбогдох заалтын хэрэгжилтийн тайланг Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбарт албан бичгээр хүргүүлж ажиллалаа.

2. Сургалт, зөвлөгөөн

- Орхон аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэсээс 2025.09.16-ны өдөр зохион байгуулсан <https://shilen.gov.mn/home> сайтад байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод байршуулах арга зүй сэдэвт сургалтад байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн хамрагдсан.
- 2025.09.19-ны өдөр Жендэрийн үндэсний хорооноос Европын холбооны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд

"Жендэрийн тухай ойлголт", "Жендэрийн дүн шинжилгээнд суурилсан хариуцлагатай бодлого, төлөвлөлт", "Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого" сэдэвт сургалтад байгууллагын жендэр хариуцсан албан хаагч хамрагдсан.



- "Хойд бүсийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар"-ын албан хаагчдыг чадавхжуулах, туршлага солилцох" сургалт Орхон аймагт зохион байгуулагдлаа. Сургалтад Хөвсгөл, Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын албан хаагчид оролцлоо.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР